

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-5</i>
<hr/>	
<i>1. Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын 10 гишүүн 2022.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>3-5</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр  
сарын 11-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 23 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, Ц.Мөнх-Оргил, Б.Саранчимэг;  
Чөлөөтэй: С.Ганбаатар, Д.Сарангэрэл, С.Одонтуяа, С.Чинзориг.

**Нэг.Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын 10 гишүүн 2022.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

**П.Анужин:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Д.Батлут, Б.Бейсен, Ц.Идэрбат, Б.Саранчимэг нар /цаашид “ажлын хэсэг” гэх/-ын гаргасан, Төсөлд дор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх иргэнд тавигдах шаардлага

4.1.Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлээ төрөөс олгох урамшууллаас суутган тооцуулах иргэн дараах шаардлагыг хангасан байна.

4.1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 7 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан тэтгэвэр тогтоолгоогүй байх;

4.1.2.нийгмийн даатгалд албан журмаар даатгуулаагүй байх;

4.1.3.төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шитгэлийг суутган төлөхийг зөвшөөрч, хүсэлт гаргасан байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 1  
Бүгд: 9  
88.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.2, 3.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 1  
Бүгд: 9  
88.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 10 минут үргэлжилж, 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж 56.3 хувийн ирцтэйгээр 09 цаг 33 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр,  
Мягмар гараг

Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим 09 цаг 23 минут

### НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**П.Анужин:** Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56.3 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийн нэрийг та бүхэнд танилцуулъя.

Анужин ирсэн байна. Баярсайхан гишүүн ирсэн. Батлут гишүүн ирсэн. Жаргалмаа гишүүн ирсэн. Сандаг-Очир гишүүн ирсэн. Чинбүрэн гишүүн ирсэн. Идэрбат гишүүн хүрэлцэн ирсэн байна. Туваан гишүүн ирцэд орсон уу. Туваан гишүүн хүрэлцэн ирсэн байна. Баярлалаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

**Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын 10 гишүүн 2022.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын 10 гишүүн 2022.06.29-ний өдөр өргөн

барьсан байгаа. Уг хуулийн эцсийн хэлэлцүүлэг өнөөдөр Байнгын хороогоор явагдах гэж байна.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу. Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын гишүүдээс 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын даргаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-т заасны дагуу төлийн зарим зүйл хэсэг дээр санал хураалт явуулалгүйгээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн. Энэ хүрээнд Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан тус хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг хуралдаж саналаа боловсруулж та бүхэнд тараасан байгаа.

Ажлын хэсгийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал танилцуулсны дараа танилцуулгатай холбогдуулан асуулт асууж болно. Асуулт асуусны дараа гүйцээн боловсруулах чиглэл өгсөн хүрээнд боловсруулсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна гишүүд ээ.

Хуулийн төслийг Байнгын хороо болон нэгдсэн чуулганы хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг хийхийг урьж байна.

Хуулийн төсөлтэй холбоотой хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийг та бүхэнд танилцуулъя.

*Б.Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ц.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга ирсэн үү. Хараахан орж ирээгүй байна М.Дондогдорж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Э.Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ирсэн байна.*

*Ажлын хэсгийн ахлагч Цэндийн Сандаг-Очир таныг танилцуулга хийхийг урьж байна.*

**Ц.Сандаг-Очир:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

*Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Д.Батлут нарын гишүүдээс 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.*

*Байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр хуралдаж, чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед хуралдаан даргалагчаас төслийн зарим зүйл, заалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх хэсэгт заасны дагуу гүйцээн*

*боловсруулах чиглэл өгсний дагуу хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулан дараах саналыг бэлтгэсэн болно.*

*Нэг.Байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед гишүүдийн олонх дэмжиж, хураалгасан төслийн 3 дугаар зүйлд нэмсэн 3.2-ын төрөөс олгох урамшуулал авах эрх үүссэн иргэн эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг уг урамшууллаас төлж болно гэснийг хуулийн төсөлд нэмэх шаардлагагүй гэж үзсэн.*

*Хоёр.Байнгын хорооны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн төсөлд Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх иргэнд тавигдах шаардлага гэсэн 4 дүгэр зүйл болон уг саналыг боловсруулсантай холбогдуулан төслийн 3.2 болон 3.3 дахь хэсгийг хасах саналыг хэвээр үлдээлээ.*

*Та бүхэн зарчмын зөрүүтэй санал болон анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналыг төсөлд шигтгэсэн хувилбарыг тараасан болно.*

*Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,*

*Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.*

**П.Ануужин:** *Ажлын хэсгийн ахлагч Сандаг-Очир танд баярлалаа. Танилцуулгатай холбоотойгоор гүйцээн боловсруулах үүрэг чиглэл өгсөн. Энэ асуудалтай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу. Нэрсээ өгөөрэй. Байхгүй байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна.*

Та бүхэнд тараасан байгаа. Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд уншиж танилцуулъя.

Нэг. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах саналыг танилцуулъя.

1.Төсөлд дор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх иргэнд тавигдах шаардлага

4.1.Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлээ төрөөс олгох урамшууллаас суутган тооцуулах иргэн дараах шаардлагыг хангасан байна.

4.1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 7 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан тэтгэвэр тогтоолгоогүй байх;

4.1.2.нийгмийн даатгалд албан журмаар даатгуулаагүй байх;

4.1.3.төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлөхийг зөвшөөрч, хүсэлт гаргасан байх.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Д.Батлут, Б.Бейсен, Ц.Идэрбат, Б.Саранчимэг /цаашид “ажлын хэсэг” гэх. Санал хураалт явуулъя гишүүд ээ. Уг зүйл 88.9 хувьтайгаар дэмжигдлээ.

Дараагийн зүйлийг танилцуулъя.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.2, 3.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя. Хуулийн төслийн 2 дугаар зүйл 88.9 хувьтай батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын гишүүдээс 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Нийгмийн бодлогын байнгын хороогоор өнөөдөр хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаанд цагтаа ирж, идэвхтэй оролцсон нийт гишүүддээ баярлалаа.

09.33 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ  
Э.СУВД-ЭРДЭНЭ